



Бөмбөгөр сумын ОУИТБС-ын өдөрлөгийн тайлан

2015 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

ОУИТБС-ын ажлын алба 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Баянхонгор аймгийн Бөмбөгөр суманд ОУИТБС-ын нээлттэй өдөрлөгийг зохион байгуулав.

Улаанбаатар хотоос Татварын ерөнхий газрын Эрдэс баялгийн татварын орлогын хэлтсийн улсын байцагч Д.Сугар, иргэний нийгмийн Төлсөн авснаа нийтэл эвслийн гишүүн Ч.Туяа, Н.Наранцэцэг, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, Г.Ганбат, А.Отгонтунгалаг, Монголын Геологийн холбооны гүйцэтгэх захирал Э.Тодбилэг, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэд захирал О.Батболд, орон нутаг хариуцсан мэргэжилтэн Х.Оюун-эрдэнэ зэрэг нийт 10 хүний баг, бүрэлдэхүүн оролцож, мэдээлэл хийв.

Бөмбөгөр сумын өдөрлөгт Баянхонгор аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Г.Хүрэлсүх, Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн х.Саруул, Байгаль орчны улсын байцаагч н.Наранбаатар, Бөмбөгөр сумын засаг дарга С.Баатар, төсөвт байгууллагын албан хаагчид, бичил уурхайчид, нутгийн иргэдийн төлөөлөл бүхий 67 төлөөлөл оролцов. Бүртгэлийг хавсаргав.



Өдөрлөг 10 цаг 30 минутанд эхэлж, сумын засаг дарга С.Баатар нээв. Хөтөлбөрт заасан сэдвийн дагуу Улаанбаатар хотоос оролцож буй төлөөлөгчид илтгэл тавьж Бөмбөгөр сумын иргэдэд 1 цаг орчим мэдээлэл, сонгол хийсний дараагаар “Тусгай зөвшөөрөл олголт ба эдийн засгийн үр нөлөө, компаниудын нийгэмд оруулж буй хөрөнгө оруулалт ба нийгмийн үр нөлөө, байгаль орчны менежмент ба тогтвортой хөгжил” гэсэн гурван дэд сэдвийн хүрээнд оролцогчдын дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүллээ.

Нэгдүгээр дэд сэдвийн хүрээнд гарсан асуулт, санал, дүгнэлтийг хураангуйлбал:

2015 оны 1 сарын 26-ны өдрөөс эхлэн шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгож



эхэлсэнтэй холбогдуулан тус суманд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших 20 өргөдөл ирснээс сумын ИТХ, Засаг дарга зөвшилцөөд татгалзсан хариуг албан тоотоор хүргүүлсэн байна. Ямар үндэслэлээр татгалзсан бэ? гэсэн Б.Дэлгэрмаагийн асуултанд сумын Засаг дарга нийт ард иргэд шинээр тусгай зөвшөөрөл олгохыг дэмжихгүй байгаа юм гэсэн хариулт өгөв. Геологийн холбооны төлөөлөл Э.Тодбилэг компаниудыг төлөөлж үг хэлэхдээ “Монгол улс бол нэгдсэн улс, төртэй, хуультай. Хуулиа л

барьж ажиллах ёстой. Хайгуул хийлгэхгүй байж болно, гэхдээ хуульд заасан үндэслэл л байх ёстой. Түүнээс зүгээр л дэмжихгүй байгаа гэж болохгүй” гэв. Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Г.Хүрэлсүхийн мэдээлснээр 2005 онд аймгийн Засаг даргын 60-р тогтоолоор аймгийн газар нутгийг бүхэлд нь тусгай хэрэгцээнд авсан байна. Ашигт малтмалын тухай хуульд зааснаар тусгай хэрэгцээнд авсан газарт ашигт малтмал хайх, олборлохыг хориглодог бөгөөд тийнхүү 60-р тогтоолоо үндэслэл болгон 10 өргөдөлд татгалзсан хариу хүргүүлэхэд Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатараас Засгийн газрын тогтоолоор тэдгээр 10 өргөдөл хүссэн газрыг нөөцөд аваагүй, лиценз олгох боломжтой гэж үзсэн тул олгосноор шийдвэрлэв гэсэн хариу ирүүлжээ. Мөн зарим хайгуулын тусгай зөвшөөрөл орон нутгаас асуухгүйгээр ашиглалтын тусгай зөвшөөрөл болсон тохиолдол гарсан байна. Тухайлбал Универсал коппер ХХК-ийн нэг тусгай зөвшөөрөл яаж ашиглалтын болсныг аймгийн удирдлагууд мэдэхгүй, мэдээлэлгүй байлаа. Гэх мэтчилэн шинээр тусгай зөвшөөрөл олголтын асуудлаар талууд ил тодоор мэтгэлцэв. Татварын тухайд Бөмбөгөр суманд зориулан хэвлэсэн Бөмбөгөр сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланд зарим ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд газрын төлбөр төлөөгүй харагдаж байсан тул энэ мэдээллийг ашиглан компаниуд хуульд заасны дагуу газрын төлбөрөө бүрэн төлж байгаа эсэхэд сум орон нутгийг анхаарлаа хандуулж, хяналт тавихыг ажлын албаны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа санал болгов. Цаашид тусгай зөвшөөрлийг олгох үйл явцыг ил тод болгох, улмаар одоо хэрэгжиж буй Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуулийн уялдаа холбоог сайжруулахад сумын ОУИТБС-ын салбар зөвлөл илүү идэвхтэй ажиллахыг санал болгосноор нэгдүгээр сэдэв өндөрлөв.

Хоёрдугаар дэд сэдвийн хүрээнд гарсан асуулт, санал, дүгнэлтийг хураангуйлбал:

Хэлэлцүүлгийн эхэнд ГОУХАН-ийн дэд захирал О.Батболд “Компанийн нийгмийн хариуцлага гэж юу вэ?” гэсэн сэдвээр илтгэл тавив. Галуут сумын Засаг дарга С.Баттулга дараах саналыг хэлэв: “Галуут сум бол алт олборлолтын 200 гаран жилийн түүхтэй. Манжийн хааны үед хятадууд алт олборлож байсан, 1940-1950 онд ар, өвөр чулуутад Чойбалсангийн үйлдвэр, 1970-аад онд Монголболгаргео гэж улсын үйлдвэрийн газар, 1990-ээд онд “Алт” хөтөлбөрийн хүрээнд анхны гар аргаар алт олборлогчид ажиллаж байлаа. Бүхий л үеийн алт олборлолтын түүх манай сумтай холбоотой байдаг. Гэхдээ олборлолт явуулсан суманд ямар ач холбогдол бий болж байна гээд үзэхээр төдийлэн харагдах зүйл байхгүй байна. Энэ нь хаа хаанаа хариуцлагагүй явж ирсэнтэй холбоотой гэж бид дүгнэдэг. Өнгөрсөн жил ОУИТБС-ын өдөрлөг манай суманд зохион байгуулагдаж, салбар зөвлөлөө сумандаа байгуулсан. Зөвлөл байгуулагдсанаар нилээд зүйлүүд тодорхой болж ирсэн. Нутгийн иргэд уул уурхайн тусгай зөвшөөрлийг дийлэнх газар нутагт олгож, бэлчээргүй боллоо гэсэн буруу ойлголттой байсан бол одоо хэдэн тусгай зөвшөөрөл байдаг, хаана байдаг талаар сайн мэддэг болсон. Одоогоор манай суманд хайгуулын 11, ашиглалтын 14 аж ахуйн нэгж байна. Нийт газар нутгийн 6%-д тусгай зөвшөөрөл олгогдсон. Гэхдээ бага хувьтай байна гээд тайвшраад сууж болохгүй. Монголболгаргео ХК одоог болтол нөхөн сэргээлтээ хийгээгүйгээс нутгийн иргэдэд хор хохирол учруулсаар байна. Нийгмийн хариуцлага гэдгийг бид хандив, дэмжлэг гэдгээр л ойлгодог байсан бол өнөөдрийн илтгэлээс хуульд заасан үүргээ биелүүлэх нь КНХ гэдгийг сайн ойлгож авлаа. Монголболгаргео ХК тухайн цаг үед нийгмийн хариуцлагаа ухамсарлаж нөхөн сэргээлтээ хийж байсан бол өнөөдөр иргэд шинээр лиценз олгох тал дээр эсэргүүцэхгүй байх байлаа. ОУИТБС-ын салбар зөвлөлийн ажлын хүрээнд бид жилд 1 удаа компаниудын тайланг сонсдог. Иргэд энэ уулзалтаас нилээд мэдлэгтэй болж байна. Тухайлбал компаниуд татвараа төлдөг юм байна, суманд ийм хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байна гэх мэт. Нөгөө талаас компаниуд хурал дээр хэлэх үггүй суухгүйн үүднээс үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болж байна. Энэ бол энэ санаачилгын үр өгөөж юм. Гэхдээ бүх компаниуд хариуцлагатай байхгүй байна. Хариуцлагагүй компаниуд бас байна. Тиймээс сум, орон нутаг, иргэдийн саналыг шийдвэр

гаргах эрх бүхий байгууллагууд сайтар авч хэлэлцдэг байх, байгаль хамгаалах ажилд барьцаа хөрөнгийг зарцуулдаг болох тал дээр анхаарч ажиллахыг та бүхэн холбогдох яам, тамгын газарт дуулгаж өгөхийг хүсч байна.”

Удаагаар аймгийн Төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Саруул улсын төсвөөс хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, сумдад хуваарилсан хөрөнгийн талаар мэдээлэл хийв. Бөмбөгөр сумын засаг дарга С.Баатар суманд хүлээн авсан хандив, дэмжлэгийн талаар мөн илтгэл тавив.

Гуравдугаар дэд сэдвийн хүрээнд гарсан асуулт, санал, дүгнэлтийг хураангуйлбал:

Хувиараа ашигт малтмал олборлогчдын Баян бөмбөгөр ТББ-ын тэргүүн Саруул товч мэдээлэл хийв. Түүний мэдээлснээр Баян бөмбөгөр ТББ нь 2009 оны 11 сард 27 нөхөрлөл, 177 гишүүнтэйгээр байгуулагдсан. Малгүй болсон, ажилгүй иргэд арга буюу алт олборлож эхэлсэн байна. 2010 оны 308 дугаар журмын дагуу талбай тогтоолгоод, Засаг даргатай гэрээ байгуулж ажиллаж байна. Одоогийн байдлаар 16 нөхөрлөлийн 98 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, нэг хүний 6000 төгрөгийн татвар орон нутагтаа төлж, нөхөн сэргээлт хийж, нийгмийн даатгалд хамрагддаг байна. 2009 онд 4га талбайд, 2010 онд 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийжээ. Байнга гар аргаар алт олборлож амь зуухгүйн тулд хоршоо хэлбэрт шилжин тогтвортой ажлын байр бий болгохыг зорьдог байна. 2013 онд 11 өрх толгойлсон эмэгтэйг түр ажлын байранд 140,400 төгрөгийн цалинтай ажиллуулж, 10 хүн оёдлын цех ажиллуулах төсөл бичээд, үйлдвэрлэл эрхлээд явж байна. Алт олборлосноос хойш 30 иргэн жижиг тэрэгтэй, 15 иргэн хашаа байшинтай болж, 3 хүн төсөл бичих сургалтанд, 5 хүн хүний нөөцийн удирдлагын академидийн, анхны тусламжийн сургалтанд тус тус хамрагджээ. Тэдний дуу хоолой хүрснээр Тогтвортой бичил уурхай төслөөс тус суманд 2012 онд 55 сая төгрөгийн халуун усыг барьж өгчээ. Түүнээс оролцогчид хэд хэдэн асуулт асуув.



Галуут сумын Засаг дарга С.Баттулга: Танайх олборлолтын цэг, тэмдэгээ тавьсан уу? Хэдий хугацаагаар гэрээ байгуулсан бэ?

Саруул: 8 сарын 25 хүртэл 3 сарын хугацаатай гэрээлсэн. Солбилцолын цэгийг газрын даамал, байгаль орчны мэргэжилтэн ирж тэмдэг тавьж өгсөн.

Г.Хүрэлсүх: Хэдэн га газарт гэрээ байгуулсан бэ? Биологийн нөхөн сэргээлт хэрхэн хийх, ямар зардлаар хийх талаар тооцоо, төлөвлөгөө бий юу?

Саруул: 2 га талбай. Бид гар аргаар л техникийн нөхөн сэргээлт хийж байгаа. 2-3 метрийн гүнзгий газарт бол яах аргагүй трактор ажиллуулах шаардлагатай байгаа. Биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, арга зүйгээр хангаж өгөхийг холбогдох төсөл хөтөлбөрт хүсэлт гаргаад байна.

Байгаль орчны улсын байцаагч н.Батбаатар: Ашигт малтмалын газраас дүгнэлт гаргуулсан уу? 11 сард очиход нэг ч нүх байгаагүй, эрүүл газар байсан. Одоо би хохирлын үнэлгээ тооцно. Энэ хохирлыг сум гаргах уу? танай ТББ гаргах уу?

Саруул: Бид эрүүл газар дээр ороогүй. 308-р журам дээр маш тодорхой зааж өгсөн байгаа. Говьалтай, Өвөрхангай гээд өөр аймгийн иргэд ирж аль хэдийнэ алт олборлож сүйтгэсэн газар дээр бид орж ажилласан.

Аймгийн Байгаль орчны газрын улсын байцаагч н.Батбаатар байгаль орчны нөхөн сэргээлтийн талаар товч мэдээлэл хийв. Том шижир ХХК нөхөн сэргээлтээ хийгээгүй орхисон байна.

Хэлэлцүүлгийн төгсгөлд Бөмбөгөр суманд ОУИТБС-ын салбар зөвлөл байгуулах талаар хэлэлцэж, ажлын албанаас арга зүйн зөвлөгөө өгснөөр өдөрлөг 17 цаг 30 минутанд өндөрлөлөө.

Хянасан:

Ш.Цолмон

Тайлан бичсэн:

Б.Дэлгэрмаа